Би ымар сайхан хэрэг вэ гэлээ. Хэн ч одий болтол иймэрхүү зүйл хэлээгүй гэдгийг би байдаг чадлаараа харууллааа. Энэ санал сэтгэлийг мини их ходолгосон болхоор би удтал ухаан бодлоо тсэгтсрүүлж чадсангүй. Эжийг нас барахаас омо нобын Танака намайг оргож авна гэдэгт нэг талаас найдсан мини үнэн боловч ногоо талаар айдас торж байв. Гуйвсан муу байшингаасаа оор хааа нэгэн газар амидарч чадах юм шиг мороодолд автсандаа ичих шиг боллоо. Нобын танакаг явсний дараа гал тогоонд ымар нэгэн ажилтай байх гэж Сатсугийн нэгэн адил хичээсэн ч, эд зүйлсийг ылган таних хундрэлтэй байв. Этсгийнхээ уйлах шиг боглуу дуугарахийг сонсоод, ичих үлай болтол хэдий хугатсаа онгорсон бол буу мэд. Тэгээд арай хийж аав руугаа очих тэнхэлтэй болоод ойртоход али хэдийн хаалганий дэргэд хүрчээ. Маргааш одор ни нобын Танакатай уулзахаар ывахайн омо бохирдсон шаахайгаа хичээнгүйлэн тсэвэрлэж, угаалга үйлдлээ. Тэгээд далай оод ажиглан суухдаа удалгүй амидралдаа анх удаа жижигхэн тосгоноосоо гарч оор ёртонтсийн хэлтэрхийг үзэх болсондоо их л додигор, хэнээс ч хамааралгүй мэт бодолд умбалаа. Сатсу бид 2 далайн бүтээгдхүүний компанид ойртон очиход загасчид барисан ангаа эргийн хавтан дээр буулгаж байлаа. Этсэг мини ч тэдэнтэй хамт ысархаг гараараа загасийг хаман авч сагсанд хийж байлаа. Хоромхон зуур бидний зуг харж тсамтснийхаа хантсүйгаар духаа арчив. Нуур тсарайний байдал ни энэ удаа ёрдийнхоосоо улам ч хүнд, хорзийисон юм шиг харагдана. Дүүрэн загастай сагснуудийг ажилчид зоон авчирч нобын Танакагийн мухлаг тэргэн дээр ачаалж байв.Би тэргэн дээр ниг арч эргэн тойрноо ажиглан суулаа. Ихэнх загасний нүд ни шил болон бултийн голорсон боловч нэг хэсгийнх ни ам ангалзаж, туслаач гэх шиг надад харагдлаа. Би тэнийг зоригжуулах санаатай:

-Бытшан загаснууд мини дээ, Сэнзүрү хотод очно ш дээ! Бух юм сайхан болноо гэв. Гэхдээ тэдэнд үнэнийг хэлээд яхав дээ. Хэсэг хугатсааний дараа нобын Танакагарч ирээд Сатсу бид хоырийг тэргэн дээр гарч хамт суу гэв. Би дунд ни суусан учир нобын Танакад ойрхон, Түүний омссон кимоногийн даавуунийи чанарийг мэдрэхээр байснаасаа нүүр үлайчихлаа. Сатсу ёрдийн афил хэнэггүй тсарайлан, байнга над руу харах мортлоо, юний ч тухай тааварлаагүй мэт байв. Би сагсанд татваганах загаснууд руу байнга эргэн харж ывлаа. Бид Иоридогоос гарч уулийн хажуу оод матсах уйд дугуйн доор том чулуу тээгэлж, тэрэг хажуу тийш түр зуур хазайж далайн алгана зам дээр унаж газар хүчтэй тсохигдсондоо амилчихлаа. Бачимдан татваганах загасийг харж чадашгүй ни. Нулимс

гуйлгэнэсэн нүдэ ноын Танакагаас нуух санаатай буруу хартал тэр мэдчихлээ. Тэр бууж загасаа аваад, бутсаж суумагтс ю болснийг асуув.

-Хоорхий загас гэтэл

-Чи миний эхнэр шиг юм гээч . туунд бараг л үхсэн загас авчирч огдоф , гэтэл хоол үнд хийх гээд хавч юм уу, оор ымар нэгэн зүйл авчирч огоод амитай голтой байвал, нүдний анисага ни бороод, тэдэнд дуу дуулж эхэлдэг гээд л бодчих. Тэгээд ноын Танака миний бодлоор эхнэр ни зохиосон бол уу гэмээр бытшан дуг, дүү ч биш залбирлийг зааж огов. Тэр дуу ни хавчинд зориулсан боловч бид угийг ни загасанд зориулж оорчлоод:

Бытшан алгана мини ээ, бутшан алгана мини !

Буддийн агуу баылагт яран хур!

Тэгээд тсааш ни урид омо миний ёр сонсоогүй буувэйн дуг зааж огов. Тэр дуг бид намхан сагсний ёроолд гантсаараа хэвтэн, товчин нүдэ эргэлдүүлэх халпини загасанд зориулан дуулав.

Тсэтсэрлэг, тариалангийн талбайд шувууд, хонин сурэг бугд л

Бүгдээрээ л унтаж байхад

Сайхан халпини ни унтаарай!

Удэш бүрийн одод

Монгон туягаа гийгуулэн тсонхоор орж ирнэ.Бид явсаар өндөр дээр гарч Сензуру хотыг харлаа.Тэнгэрт бүрхсэн үүлтэй бүүдгэр өдөр байв.Йоридогоос гарч харсан миний анхны ертөнц бөгөөд нэг ч их юм алдаагүй болохыг ойлгов.Далайн булан тойрсон гүдгэрийн дундах сүрлэн дээвэр үргэлжилж,цаашлаад төмрийн өнгө нүднээ алаглав. Далайгаас зайдуу газрын байдал нь сорви мэт гүнзгий гуу татаагүйсэн бол сайхан харагдахаар санж.Сензуру хот заваан өмхий ажээ.Далайгаас хүртэл ялзарсан загас байгаа мэт мүүхай үнэр ханхална. Эргүйн дагуу манай тосгоны дэргэдэх далайн мөгөөрс шиг муудсан ногоо хөвнө.Хагарч холцорсон завинууд бие биетэйгээ тулалдсан мэт харагдах аж.

Ноён Танакаг гарч ирж Японы эргийн далайн бүтээгдэхүүний компаний гол байшинд дуудтал Сацу бид хоёр эргэ дээр суугаад хүлээв.Загасны хэвлийд байгаа юм шиг загас ханхалсан урт хонгилоор бид явав. Хонгилын эцэст буй албан өрөө нь надад таалагдлаа. Бид дээшээ гарах хивсэнцэр дэвссэн хэдэн шатны дэргэд ирлээ. Чухам энэ л надад таалагдсан бололтой. Дээр байрлах шал ендер сэтгэгдэл терүүлдэг юм хойно доо. Гэхдээ ямар ч байлаа гэсэн үүнээс илүүг би үзээгүй байлаа.Одоо бодоход Япон тэнгисийн жижигхэн тосгоны загасны бөөний худалдаачны албан ерее хэн нэгэнд тиймэрхүү сэтгэгдэл терүүлнэ гэдэг инээдтэй л байхгүй юу. Буйдангийн дэргэд тависан зузаан олбог дээр сууж байсан эмэгтэй биднийг ороход өндийгөөд буцаж өвдөглөн эвтэйхэн суув.Тэр эмэгтэй их л настай, бас ч их ууртай харагдах нь үүнээс илүү тайван бус хүн дахин тааралдахгүй биз ээ гэмээр.Эмэгтэй кимоногоо имрэхээ боливол нүднийхээ буланг арчих юм уу хамраа үрээд эхэлнэ.Тэгсэн мөртөө ийм олон хэрэггүй

хөдөлгөн хийж байгаадаа бас эвгүйцэж буйгаа бүх л байдлаараа харуулах аж.Ноён  
Танака түүнд хандаж:

-Энэ Чио сан,эгч нь болох Сацу сан гэв.Би бага зэрэг инээвхийвэл,Мэгдүү авгай толгой  
дохилоо.Дараа нь хүндээр санаа алдсанаа, шилэн хүзүүн дээрх мэнгээ оройдоод

эхлэв.Би харцаа буруулах гэсэн боловч түүний нүд намайг цоо ширтэнэ,

-За,чамайг Сацу сан гэдэг үү? гэж тэр авхай намайг ажиглангаа хэлэв.

-Сацу нь би юмаа гэж эгч хэллээ.

-Хэдийд төрсөн бэ?

Мэгдүү авхай над руу хараад байх шиг болохоор нь би Сацугийн өмнөөс:

Авхай гараа сунган надад хүргэлээ.Гэхдээ үүнийгээ их л сонин хэлбэрээр эхлээд хацар  
руу чичилж хатгаж үзэх үед царайг нь харвал сайн санаа агуулж байгаа бололтой.

-Энэ их хөөрхөн охин юм байна тиймээ? Нүд нь ер бишийн гээч. Бас тэгээд ухаалаг

бололтой юмаа. Дүхийг нь хараачээ хөөе гэснээ эгч рүү эргэн харж:

-За, сайн байна. Үхэр жилтэй гэдэг нь арван таван настай,Сугар гариг, зургаан цагаан  
өнгө. Жаахан наашлаарай.

Сацу ойртлоо. Мэгдүү авхай эгчийн нүүрийг харцаараа болон хурууныхаа өндгөөр  
шунжиж эхлэв.Сацугийн хамар чихийг хэдэн талаас нь удтал ажиглаж,чихний омгийг нь  
хэдэн удаа имрээд,дууслаа гэсэн янзтай над руу эргэв.

-Чамалг бичин жилтэй гэдгийг би хараад л мэдлээ. Чиний уг үндсэнд ямар их ус байнаа.

Найман цагаан өнгө , санчир гариг.Чи тун сайхан охин юм.Нааш ир. Одоо болхоор Сацуг  
шинжсэн шигээ чихний омгийг имрэх татах зэргээр намайг судалж эхэллээ.Хүзүүнийхээ  
мэнгээ оролдсон тэр хуруугаа надад хүргэлээ гэсэн бодол өөрийн эрхгүй төрөв.Биднийг  
шинжиж үзүж дуусаад ноён Танакад зөвхөн түүнд ойлгогдох дохио өгмөгц , тэр хаалга  
сайн хаагаад гарав.Мэгдүү авхай Сацугийн цамцыг тайлж, эргүүлж тойруулж,гарыг нь  
өргүүлэн,нүрууг нь бас бариж тэмтэрч үзлээ.Би ч царцчих шиг боллоо.Гэхдээ би Сацуг  
нүцгэн байгааг урьд нь харж байсан боловч Мэгдүү авхай эгчийг минь,Сужийн хүүгийн  
өмнө өөрөө хувцасаа тайлдгаас илүү ичгүүртэйгээр үзэж байх шиг санагдлаа.Дараа нь  
Сацугийн емдийг шувтлаад хэдэн удаа эргүүлж тойруулав.

-Агтавчаа тайл гэв.

Сацугийн нүүрийг харвал хэдийгээр ичингүйрч байсан ч гэсэн агтавчаа тайллаа. Мэгдүү  
авхай түүний мөрөн дээрээс бариад өндөр олбог дээр суулгалаа.Сацу чармай нүцгэн  
баилаа.

Гэхдээ яагаад энэ болгоныг туулах ёстойгоо тун ч ойлгоогүй бололтой. Ийм асуулт  
өөртөө тавих ч цаг байсангүй. Мэгдүү авхай чанга хашгирах зуур тасхийтэл алгадах  
чимээ сонсдов.

Сацугийн хөлийг алгадсан байх, дараа нь харахад улийсан байв. Дараа нь Сацуг  
хувцаслахыг зөвшөөрөв. Эгч маань уйлж, мэгшиж байсан боловч би түүний зүг харж  
түвдсэнгүй.

Мэгдүү авхай мөн дээрхийн адил намайг үзэв. Хоромхон зуур өмдийг минь шувталж,  
хөлийг өвдгөөр минь холдуулаад Сацутай адил бас эсэргүүцэж болохгүй гэсэн бололтой  
алгадахад нь уйлмаар санагдав.2 хөлний минь хооронд хуруугаа дүрэх нь чанга чимхэж  
байх мэт боллоо. Намайг хувцаслахыг зөвшөрөх үед би өөрийгөө голын ус хаасан далан  
мэт санав. жаахан хүүхэд шиг уйлж ноён Танакагийн нүдэн дээр шившигээ тарихгүйг  
хичээлээ.

- Охидууд эрүүл юмаа гэж авгай орж ирсэн ноён Танакад хэлээд бүх л талаараа тэнцэж байна гэлээ. Хоёулаа л цоороогүй. Эгч нь модон махбодитой, дүү нь ус ихтэй. Их аятайхан охин, тийм байгаа биз? Эгч нь болохоор түүнийг бодвол тариачин юм даа. -Миний бодлоор хоёулаа л өөр өөрийнхөөрөө хараа татмаар охид. Би таныг гаргаж өгье. Тэгээд замдаа ярилцъя. Охидууд эндээ намайг хүлээж бай гэв. Ноён Танакаг гармагц би Сацу өөд эргэж харлаа. Эгч өндөр олбог дээр өнцөгдөж суугаад адар өөд ширтэж байна. Энгийн бус нүүрний хэлбэрээсээ болж нулимс нь хамрын самссааны дээр тогтсоныг нь, түүний гоморхсон байдлыг хараад би цурхиран үйлчихлаа. Энэ болгонд би буруутай мэт санагдаж, цамцныхаа сэжүүрээр нулимсыг нь арчив.

- энэ муухай авгай хэн юм бол? гэж эгч асуув

- мэрэгч юм бол үү даа. Ноён Танака бидний тухай аль болохоор их мэдэх гэж...

- гэхдээ яагаад ийм муухай аргаар биднийг шинжиж байгаа юм бэ?

- Сацу, та ойлгохгүй бна гэж үү? Ноён Танака биднийг үрчилж авах гэж бна шүү дээ.

Үүнийг сонсоод тэр нүдэнд нь ямар нэг цог орчихсон юм аятай нүдээ анивчив.

- чи юу яриад бна аа? Ноён Танака биднийг үрчилж авч чадахгүй шүү дээ.

- гэхдээ аав минь өндөр настай... тэгээд одоо эжий минь өвдчөөд, ноён Танака бидний ирээдүйд санаа тавьж байна гэж бодох юм. Бидний төлөө санаа тавих өөр хэнч байхгүй. Энэ үгнээс Сацу бүр хөшиж орхив. Эгч маань гуйвсан муу байшиндаа бид урьдын адил амьдарч, юу ч өөрчлөгдөхгүй гэж өөрийгөө итгүүлэх гэж орооцолдох нь надад ажиглагдлаа. Тэрээр надаас бүх л мэдээллийг бага багаар хөөсөндөр шиг шингээж авсаар байгаад цаахан азасны дараа нүүр нь аажмаар тэнийж, ямар ч яриа болоогүй юм шиг өрөөг тойруулж харж байлаа.

Ноён Танакагийн байшин хотын захад, гудамжны эцэст байдаг ажээ. Манай байшинг далай ариулдаг шиг тэдний байшинг зуун наст анхилуун нарс хүрээлж орчны агаарыг хүчтэй ариулдаг ажээ. Би нэг үнэрийг нөгөөгөөр сольж чадах бол үү гэж бодмогцоо, сэтгэл дотор хоосрох шиг боллоо. Энэ бол хаднаас буугаад хадныхаа хэлтэрхий нь болж өөрөө чулуужихтай адил юм даа. Эдний байшин Сензүрудээ л хамгийн том нь бөгөөд манай тосгоны сүм шиг маш олон хөвөөтэй ажээ.

Ноён Танака хаалганы дэргэд гутлаа тайлаад зориулалтын тавиур дээр тавьлаа. Сацу бид 2т тайлах юм байсангүй ээ.

Гэнэт араас 1 юм хөнгөхөөн цохих шиг болоход харвал нарсны боргоцой миний хөл дор уналаа. Эргэж хартал хөвсгөр үстэй, миний хэрийн жижигхэн охин нарсны ард нуугдчихав. Модны араас цухуйж инээмсэглэснээ намайг хамт тоглохыг урин эргэн харсаар гүйн одлоо. Би урьд нь хэзээ ч ямар нэгэн охитой танилцаж байсангүй, энэ нь хачирхалтай дуулах байх л даа. Тосгоныхоо охидыг мэднэ л дээ гэхдээ бид хамт л өссөн болохоор танилцана гэдэгтэй ойролцоо зүйлтэй учирч байсангүй. Гэвч Ноён Танакагийн охин Кунико үнэхээр найрсаг зантай охин бсан болохоор нэг ертөнцөөс нөгөөд шилжих явдал нь тийм ч хүндрэлтэй санагдсангүй. Хаьсан мөчрөөр босгож чулуу, боргоцойгоор өрөө тасалгаа хийсэн тоглоомын байшинд оруулан барьж автлаа ойд охины араас хөл нүцгэн л хөөцөлдөж байв.

Нэг өрөөнд нь охин надад хагархай аяганд цай чанаж өгч байгаа болж, нөгөө өрөөнд, шуудайны таараар хийж хогоор дүүргэсэн хүүхэлдэй, Тарогий нь ээлжээр бүүвэйллээ.

Таро нь танихгүй хүнд амархан дасч, харин Куникотой адилхан өтнөөс айдаг юм билээ.

Өт хараад намайг гаргаад хаяад өгөөч гэж гуйх ба Таро нь охины тусламжтайгаар үйллаа.

Кунико миний охин дүү болоосой гэж ямар их хүссэн гээч. Агуу хүчирхэг нарс мод, тэдний үнэр, тэр байтугай Ноён Танака ч энэ хүсэлтэй минь харьцуулбал тийм ч чухал биш санагдаж эхэллээ. Ноён Танакагийн байшин дахь амьдрал, Йоридо дахь амьдрал 2ын ялгаа нь хийж буй хоолны үнэр, аман дахь амттайхан хоолны амт 2 шиг үнэхэр их зөрөөтэй байлаа.

Харанхуй болмогц бид хөл, гараа горхинд угааж ирээд байшинд орж дөрвөлжин ширээг тойрон шалан дээр суув. Чанасан хоолны уур дээшээ тааз хүрэхэд, харин бидний толгой дээр цахилгаан чийдэн өлгөөстэй байгаа нь намайг гайхшрууллаа. Оройн хоолонд шарсан алгана загса, давсалсан ногоо, шөл, жигнэсэн будаа зэргийг зарц нар авчраад өгөхөд нь идэх гэж байтал гэрэл унтарчихлаа. Иймэрхүү юм ойр ойрхон болдог бололтой Ноён Танака инээлээ. Зарц нар нь 3 модон хөл дээр дүүжилсэн дэнлүүнүүдийг асааж эхлэв.

Хоолны үед чив чимээгүй байв. Би Танака авгайг гайхалтай сайхан эмэгтэй гэж дүрслэн бодож байсан чинь арай эелдэг инээмсэглэл тодруулсан мөртөө яг өтөлсөн Сацу шиг харагдлаа. Хоолны дараа авгай, Сацу 2 "го" даам тоглов, Ноён Танака босоод зарцыг кимоно авчир гэв. Түүнийг гарч явсны дараа Кунико намайг гараараа дохиод дуудлаа.

- Бид хаашаа явах юм бэ? гэв

- Чимээгүй? Бид аавын араас явъя гэлээ.

Би түүнийг гэрээс гараад явах болгонд дагадаг юм. Энэ миний бяцхан нууц гэлээ. Бид нарийхан замаар хэдэн байшин өнгөрөөд Сензуругийн гудамжинд гараад Ноён Танакагийн араас хлхон зайд даган хэдэн хормын дараа цаасан хаалтаар битүүлсэн дотроо гэрэлтэй цонхтой байшингийн гадна ирлээ. Кунико нэг хаалтны завсраар шагайж эхэллээ. Байшингаас дуулах, ярилцах, инээлдэх дууссондоно. Хэдэн минутын дараа Кунико цонхноос холдож, чийрс дээр 4 эрэгтэй хүнээр хүрээлүүлсэн Ноён Танака суугааг харах ээлж надад ирлээ. Эрэгтэйчиүүдийн нэг нь залуу эмэгтэйд шат барьж өгсөн чинь даашинзан доорх бүх л юмыг нь харж болохоор байсан тухай түүх ярьж байлаа.

Ноён Танакагаас бусад нь инээд алдах агаад харин тэр хөшгөөр халхалсан буланруу доош харан суух аж. Настайвтар эмэгтэй шилэн аяга барин исгүүн аягаллаа. Яагаад бүгдээрээ исгүүн аяглах хөгшин авгай хүртэл инээгээд байхад харин Ноён Танака л тэр зүгт харсан чигээрээ томоотой сууж буйг би ойлгосонгүй. Би завсраар нүдээ салган Куникоруу эргээд:

- энэ ямар газар вэ? гэж асуулаа

- энэ гейша нар эрчүүдийг зугаацуулдаг цайны газар юмаа. Эцэг маань энд бараг орой болгон ирдэг. Энэ түүнд юугаараа таалагддаг юм бу, бүү мэд. Эмэгтэйчүүд ундаа аягалж, эрчүүд элдэв түүх ярьж, заримдаа хамтдаа дуулж, орой явахдаа бүгд жаахан уусан байдаг.

Би дахийд цонхны завсраар харж байв. Хэн нэгний сүүдэр ханан дээр туссанаа цагаан цэцэгтэй зөөлөн ягаан кимоно өмссөн эмэгтэй орж ирлээ. Алтлаг шаргал өргөн бүс нь бүсэлхийг нь тодруулж, амьд багаан сараана цэцэг үсийг нь чимэх ажээ. Би хэзээ ч ийм гоёмсог хувцас үзээгүй байлаа. Йоридогийн ямар ч эмэгтэй ёрог даавуунаас илүү, сайндаа л жирийн хээ угалзаар чимсэн олсон даавуунаас илүү гоё хувцас өмсдөггүй юм. харин өмссөн хувцасаа бодвол эмэгтэй тийм ч сайхан биш санагдлаа. Уруул нь таглаж

хүрэхээргүй шүд нь урагш арзайн түрсэн харагдана. Толгой нь нарийхан гонзгор болохоор багад нь 2 банзны завсар хавчаагүй байгаадаа хэмээн би бодлоо. Намайг тэр эмэгтэйд цударга биш байна гэж та бодож магадгүй. Гэхдээ Ноён Танака хэн ч сайхан гэж хэлэхээргүй тэр хүүхнээс нүдээ салгахгүй байгаа нь бүр гайхаш төрүүллээ. Бусдыг инээд алдаж байхад Ноён Танака түүнийг харсаар л суух агаад исгүүн аягалан тонгойх хүүхэн налхийх нь энэ 2 бие биенээ сайн мэддэг юм байна гэдэг нь харцнаас нь мэдэгдэж байлаа.

Одоо дотор юу болж байгааг харах ээлж Күникогийнх боллоо. Сониучирхан харж ханаад бид гэр өөдөө явж, одод түгсэн тэнгэр дор нарсан төгөлд халуун усанд жаал суулаа. Энэ өдөр надад тохиолдсон үйл явдлыг эргэцүүлэн бодож тэнгэр ширтэн удтал халуун усанд сууж би чадах байлаа. Гэвч Күниког халуун ус ядрааж, нойрыг нь хүргэсэн учир зарц нар биднийг гэрт орууллаа.

Күнико бид 2ыг унтахаар хэвтэхэд Сацу хэдийн унтаж байв. Бид 2 бие биендээ наалдан хэвтэж гар гараасаа барилаа. Би баяр жаргалд умбан Күникод:

- намайг чамтай хамт амьдарна гэж чи мэдэж байсан уу? гэж шивнэв.

Миний асуулт түүнийг нүдээ нээн орон дээрээ өндийж суутал нь гайхшруулна гэж би бодсон боловч унтаж байгаа хүний жигд сайхан амьсгаа сонсогдсон болохоор миний асуулт түүнийг нойрноос нь сэрээсэнгүй ээ.

### БҮЛЭГ 3

Буцаад гэртээ иртэл эжий минь улам муудсан шиг харагдлаа. Гэвч ямархуу харагдаж байсныг мартсан ч байж магадгүй. Ноён Танакагийн байшинд тамхи, модны давирхайн үнэр ханхалж байсан бол манай муу байшин үгээр илэрхийлэхийн аргагүй эжийн өвчний үнэр нэвт шингэсэн шиг санагдана. Үдийн дараа Сацу тосгонд ажиллахаар явж, Сүжи авхай ирж эжийг усанд оруулахад надад тусаллаа. Бид эжийг байшингаас өргөн гаргахад нүдний цагаан нь булингартай, цээж нь мөрнөөсөө илүү өргөн болчихсоныг нь ажиглав. Ээжийг харахад үнэхээр нүд халтирмаар болжээ. Нурууг нь би байнга үрж угаадаг учир бие нь Сацугийнхаас ч илүү чийрэг, толигор тэр эмэгтэйнэнэ зун нас барна гэдгийг төсөөлөн бодоход бэрх байв.

Шөнө орондоо хэвтсэн хойноо бий болсон нөхцөл байдлыг хэдэн талаас нь эргэцүүлэхийг хичээж юу ч боллоо гэсэн сайнаар эргэх болно гэж өөртөө итгэл үнэмшил төрүүлэхийг оролдов. Эжийгүгээр бид хэрхэн амьдрах тухайгаа юуны өмнө төсөөлөхийг хичээлээ. Бид амьд үлдлээ ч гэсэн, Ноён Танака биднийг үрчилж авлаа ч гэсэн гэр бүл маань хадгалагдах бол уу? эцэст нь Ноён Танака зөвхөн биднийг үрчилж авах төдийгүй эцгийг минь хүртэл үрчилж авах юм байна гэсэн бодол толгойд орж ирлээ. Эцсийн эцэст эцгийг минь ганцаараанг орхиж болохгүй биздээ. би ихэвчлэн өөрийн хүсэл тэмүүллээ бүрэн биелэгдэх боломжтойд итгэхээс нааш унтаж чаддаггүй хүн. Ийм бодлыг өөртөө итгүүлэх гэсэн энэ удаагийн оролдлого тун бүтэл муутай болэ хэдэн 7 хоног бараг унтаж чадахгүй, мангар юм шиг явж байлаа.

зуны халуун өглөө тосгоноос ирж явахдаа ард минь чимээ гарах шиг болоход эргэн харвал ноён Сүжи гүйж явна. Тэр амьсгаадан улайчихсан амьтан намайг гүйцэж ирээд амьсгаагаа жаахан дарснаа:

- Ноён Танака чамайг эгчтэйгээ ... аль болохоор түргэн тосгонд ирэхийг хэлүүллээ...гэдэг



юм байна. Өглөө эцэг минь загасчилахаар яваагүйд нь би гайхаж байлаа. Тэгэхээр нөгөө юм болох нь гэж ойлгов.

- Эцэг минь яах билээ? ноён Танака түүний тухай юу ч хэлээгүй юу? гэж асуулаа.

- Чио сан, алив явъя. Явж эгчийгээ олж ир гэж тэр хэлэв.

Хэдийгээр энэ нь надад таалагдаагүй ч гэсэн гэр өөдөө гүйлээ. Аав ширээний ард сууж модон ширээний банзны завсрын хирийг хумсаараа маажсан шиг байх аж. Сацу зууханд модны нүүрс шидэж сууна. Тэд хоёулаа нэгэн аймшигтай юм хүлээх мэт харагдана.

- Ааваа, ноён Танака Сацу бид хоёрыг тосгонд хүлээж байна гэнэ гэж нам гүмийг эвдэн хэллээ.

Сацу хормогчоо тайлж дэгээнд өлгөөд гараад явчихав. Аав дуугүй л сууна. Тэгээд саяхан Сацугийн байсан газар луу хялам хийснээ харцаа бууруулж толгой дохив. Яг энэ үед хажуугийн өрөөнд ээж минь нойрон дундаа гиншлээ. Намайг гүйцэж очиход Сацу бараг тосгон хүрсэн байлаа. Энэ өдрийг аль хэдийнээс олон дахин дотроо дүрслэн бодож байсан хэдий боловч ингэтлээ би айдаст автах юм гэж ер бодсонгүй. Харин Сацугийн хувьд тосгон хүртэл явах нь өдөр болгоныхоос даанч ялгарахгүй байх шиг. Гартаа наалдсан үнсийг ч цэвэрлээгүй болохоор үсээ янзлахдаа нүүрээ үнс болгочихлоо. Түүнийг ноён Танака ийм байдалтай бүү хараасай гэсэндээ очиж нүүрийг нь цэвэрлэх гэтэл эгч миний гарыг түлхээд хаячихлаа.

Компаний байранд хүрэхдээ ноён Танакад мэхийн ёсолж мэндлэхдээ биднийг хараад баярлах байх гэсэн чинь тун хүйтэн царайтай байх нь тун гэнэтийн юм боллоо. Үйл явцыг миний дотроо урьд нь дүрслэн бодож байснаас шал өөрөөр эргэх бололцоотойг анх удаа л ойлгов. Ноён Танака биднийг мұхлаг тэрэгний тэвшин дээр суулгахад нь бид тэдний гэр лүү явах гэж байна, охин эхнэр хоёр нь ч бас биднийг өргөж авах ёслолд оролцох нь гэж бодлоо.

- Ноён Сүжи бид хоёр урд талд хамт явна. Жизу-сан, та хоёр ард нь суу гэж хэлэв. Чухам яг Жизу-сан гэж хэлсэн. Миний эгчийн нэрийг ингэж өөрчилсөн нь намайг гомдоосон боловч харин Сацу үүнийг ер анзаарсангүй. Эгч маань мұхлагны зайдуу буланд, загасны хоосон сагсны дунд, нялцгай гадаргууг алгаараа түлж сууснаа мөн энэ л гараараа нүүрнээсээ ялаа үргээлээ. Би Сацу шиг нялцгар зүйлд тайван хандаж чаддаггүй бөгөөд энэ мүүхай үнэрээс яаж салах, ноён Танакагийн гэрт ямар сайхан бол, гараа цэвэрлэж, хувцасаа угаачих юмсан гэхээс өөр юу ч бодож чадахгүй явлаа.

Цааш явах бүхий л хугацаанд Сацу бид хоёр нэг ч үг солиогүй бөгөөд харин мұхлаг тэрэг уул даван Сензуру харагдаж эхлэх үед Сацу гэнэт:

- Галт тэрэг! гэж дуу алдав.

Хаа нэгтээ холд хот руу яваа галт тэрэг олж харах санаатай би мұхлагнаас толгойгоо цухуйлган хартал бид ерөөсөө ноён Танакагийнх уруу яваагүйг ойлголоо.

Мұхлаг тэрэг хотын захад байх төмөр замын тавцанд түлж очоод зогслоо. Шүүдай, сагсны дунд олон хүн шавааралджээ. Олны дунд Мэгдүү авхай, кимонотой өндөр гоолиг, муурынх шиг зөөлөн хар үстэй хүнтэй хамт байхыг олж харлаа. Тэр хүн гартаа хувцастай цүнх бариад зогсох нь сагс барьсан загасчид, фермийн эздийн дунд мэдэгдэхүйц ялгарах ажээ.

Мэгдүү авхай эрэгтэйд нэг юм хэлэхэд биднийг ажиглаж эхэлмэгц намайг айдас нөмрөөд авав. Ноён Танака түүнийг Бэкку гээд биднийг танилцуулав. Ноён Бэкку над руу удаан ширтсэнээ Сацуг болохоор гайхах янзтай ажиглах шиг надад санагдлаа.

Ноён Танака түүнд:

- Йородогоос би Сужиг авчирлаа. Өөртэй чин хамт явуулах уу? Энэ хүн охидыг таних учраас би түүнийг хоёр өдөр санаа амар явуулж болно шүү гэлээ.

- Үгүй үгүй гэж ноён Бэкку эрс хэлэв.

Мэдээж би үйл явц ингэж эргэнэ чинээ санаагүй болохоор хаашаа явах юм бэ? гэж асуухыг оролдлоо. Хэн ч намайг сонсох сонирхолгүй мэт болохоор нь энэ асуултыг би өөрөөсөө асуулаа. Ноён Танака бидний талаар Мэгдүү авхайн хэлсэн үгэнд сэтгэл ханалгүй, энэ инээдэмтэй горзгор хүнтэй хамт явуулж хувь заяаг минь тодруулах гэж байна, тэгээд бид түүнрүү эргэж ирэх юм байна гэж бодлоо.

Намайг өөрөө өөрийгөө тайвшруулах гэж оролдож байх зуур Мэгдүү авхай ялдам инээмсэглэл тодруулан Сацу бид 2ыг бохир тавцангаар дагуулан урагш явлаа. Биднийг хэн ч сонсохгүй нэлээд холдсон хойно түүний нүүрнээс инээмсэглэл нь алга болж:

- Одоо сонсож бай. Хоёр муу новшийн охид минь! гээд эргэж харснаа биднийг хэн ч ажиглахгүй байгааг далимдуулан Зууланг минь алгадаад авлаа. Би өвдсөн гэхээсээ цочсондоо бахирчихлаа.

- Та нар нэр хөөдөв өө. Та нараас бүх юмны төлөөс нэхнэ шүү. Ноён Бэкку их хатуу хүн, хэлсэн болгоныг нь дагаарай. Галт тэрэгний суудал доогуур мөлх гэж тушаасан ч үг дуугүй биелүүлээрэй, ойлгов уу?

Хэдийгээр Мэгдүү авхайн төрхийг ажвал хариу хэлэхгүй бол дахиад цохих нь гэмээр байсан ч, би айсандаа үг дуугарч чадахгүй болжээ. Миний бодсончлон авгай гараа сунган хүзүүг минь өвдтөл чимхэж байгаа нь хаанаас ч хамаагүй хазаж аваад байгаа нэг хачин амьтантай хамт нэг хоолойд орчихсон шиг санагдав. Би тэссэнгүй эхэр татаж эхэллээ.

Хэсэг хугацааны дараа ноён Танака ирээд:

- Юу болоо вэ? Энэ охидод ямар нэгэн юм нэмж хэлмээр байгаа бол миний дэргэд хэлээрэй. Та эдэнтэй ингэж харьцах үндэсгүй шүү гэв.

- Эдэнд олон юм хэлмээр байвч галт тэрэг ирлээ гэж Мэгдүү авхай хэллээ.

Нээрээ булан тойроод галт тэрэг гарч ирлээ. Ноён Танака биднийг ачаа бараагаа шүүрэн авч бүжигнаж эхэлсэн хүмүүсийн дэргэд аваачлаа. Удалгүй галт тэрэг ирж бидний өмнө зогслоо. Даргар кимонотой ноён Бэкку Сацу бид 2н дунд чихэн ороод тохойноос минь чирж вагонд суулгав. Эцэст нь ноён Танака бидэнд ямар нэгэн үг хэлсэн боловч юу ч сонсохгүйгээр гутарсан байв. Магадгүй энэ нь:

- Мата по “Бид дахин үулзанаа”

эсвэл:

- Матте йо “Хүлээгээрэй”

үгүй бол:

- Ма деио “За хөдлөөрэй” ч гэсэн байж магад.

Намайг цонхоор харахад ноён Танака мұхлаг тэрэг рүүгээ очиж, Мэгдүү авхайн гараа кимоногоороо арчиж байлаа. Мөчийн дараа эгчийн дуу гарч:

- Чио сан гэв. Би сэтгэл өвдсөндөө газар доогуур ороход бэлэн, гараараа нүүрээ дарлаа. Эгч миний нэрийг дуудсан нь л хүрэлцээтэй байсан бөгөөд цааш нь юу ч хэлэхгүй байсан ч болох байлаа.

- Бид хаашаа явж байна аа, чи мэдэх үү? миний бодлоор Тийм Үгүй гэсэн нэг л үг хангалттай байх байсан. Түүнд бидний хаашаа явж байгаа нь ч чухал биш байсан байж

магадгүй, гэхдээ тэртэй тэргүй би мэдэхгүй юм чинь. Бэкку нэртэй горзгор хүнээс энэ тухай асуухыг оролдсон ч тэр хариу хэлсэнгүй. Урьд өмнө нь хэзээ ч ийм хүнийг харж байгаагүй мэт тэрээр Сацу өөд ширтсээр байлаа.

Эцсийн эцэст дургүй нь хүрсэн бололтой:

- Муу загас! Та 2 ямар муухай өмхий байнаа гэж хэлэв.

Тэр цүнхнээсээ сам гаргаад Сацугийн үсийг самнаж өвдтөл нь угзарч харагдав. Сацу үйлчихлаа. Болж байгаа болгонд буруутайгаа мэдрэхийн зэрэгцээ эгчийгээ зовохыг харж сууснаас тэр хүн намайг зовоосон нь хамаагүй дээр байх байлаа.

Настай тариачин авгай Сацуд лууван сарвайгаад хаашаа явж байгааг асуулаа.

- Киото руу гэж Бэкку өмнөөс нь хариулав. Түүний хариултаас миний дотор муухайрч, Сацугийн нүд рүү ч харж чадахгүй байв. Сензуру хот ч алсын хот шиг санагдав.

Киотогийн тухайд ярих юм алга. Миний хувьд бол нэгэн удаа Миура эмчээс сонссон Гонконг юмуу, Нью-Йорк шиг сонсогдож байлаа.

Бид галт тэргээр удаан явсан боловч энэ хугацаанд юу ч идсэнгүй ээ. Бэкку цүнхнээсээ боодолтой гүнжид түрхсэн тутарганы базмал гаргаж идэхийг нь шууд л харлаа. Түүний ёрдойсон ясан гараараа будааны базмалаа авч нүдээ ч өргөлгүй жижигхэн муухай амандаа чихэхийг нь хараад би дахиад иймэрхүү нэг ч эрүү шүүлтийг давахгүйгээ мэдэв.

Киото л юм байх гэж бодсон нэгэн том хотод ирээд тавцан дээр буулаа. удалгүй өөр галт тэрэг ирэхэд бид тийшээ орж, жинхэнэ Киото руугаа явлаа. тэнд түрүүчийнхийг бодвол илүү олон хүн байсан болохоор тувт зогсоогоор явлаа. орой болохын хирд Киотод ирэхэд би гэдэг амьтан бүх л өдөржингөө усан хүрхрээ буусан хад ямар байх вэ, тийм л болсон байв.

галт тэрэг Киотод ойртох хооронд би хотыг бага зэрэг харлаа. жаахан байзнаад алсад харагдах уулын оройгоос дутахгүй өндөр барилгуудыг харлаа.

ийм том хот байдаг гэдгийг одоо болтол төсөөлөхгүй явжээ. одоо ч гэсэн галт тэрэгний цонхоор хотыг харах болгондоо гэрээ орхин гарсан анхны өдөр төрсөн айдас, хүйдэс, хоосрон өнчирсэн тэр мэдрэмжээ би дурсан санадаг юм. ноён бэкку бид 2г тохойноос минь бариад алхах нь худагнаас 2 ус хувин аваад яваа юм шиг л байв. хэрвээ мөчийн хэртэй тавьчихвал зугтаачихна гэж бодсон байж болох, гэхдээ би яагаад ч зугтахгүй байсан. тэр биднийг хаашаа ч авч явж байгаа гэсэн далайн ёроол мэт адилхан ээлгүй энэ аварга том байшин, гудамжин дүнд ганцаараа үлдэхээс илүү аймшиг байхгүй билээ. тэр 1930 оны үед Киотод маш олон хүн тэрэг байсан болохоор буудлын дэргэд эгнээ үүсгэн зогсоно. бид мұхлагтай хүн тэргэнд ноён бэккугийн хоёр талд суугаад явахдаа түүнийг миний бодсоноос ч илүү ясан хэлхээ болохыг мэдэх нь тэр.

тэр хүн тэрэгний хөтлөгчид:

- жион дахь Томинаго-чо руу гэв.

хөтлөгч дүүгүйхэн хөдлөв. хоёр нарийхан зам өнгөртөл явсны дараа би зүрхээ чангалан байж ноён Бэккугээс:

- бид хаашаа явж байгааг хэлж өгөөч? гэв. тэрээр хариулахгүй болвуу гэтэл:

- та нарын шинэ байшинд гэв.

үүнийг сонсоход миний нүд нулимсаар дүүрч, Сацу мэгшиж эхэллээ. би ч гэсэн уйлахад бэлэн байсан боловч ноён Бэкку гэнэт сацуг эхэр таттал нь цохиод авав.

би ч гэсэн хөмхийгөө зууж тэслээ. удалгүй бүтэн Йоридогоос ч өргөн санагдсан өргөн чөлөө рүү эргэлээ. гудамж дүүрэн машин мұхлаг тэрэг, унадаг дугуй, олон хүн

багширсан замын цаанах нөгөө захыг арай чүү харлаа. би урьд нь машины зургыг харж л байсан л даа. гэхдээ тэднийг хүнд үйлчлэхэд зориулж биш, харин хүмүүсийг зовоох харгис ширүүн эдлэл болгосон шиг тэр үед санагдсан. бүрэнхий болох тусам улам сэтгэл тавгүй болж том хотын гэрэл гэгээнд анх орсон болохоор амьдралдаа ахиж хэзээ ч ийм догдлол мэдрээгүй билээ. ноён Танакагийн гэрт оройн хоол идсэн оройгоос өөр газар цахилгаан гэрэл би үзээгүй байлаа. энд болохоор бүх л байшингийн цонхнууд доороосоо дээшээ цөм гэрэлтэй.

дараа нь гудамжны нөгөө талд мундаг том вааран дээвэртэй Минамиза театрыг харсан нь надад ордон мэт харагдана. хүн тэрэг дахиад жаахан яваад хоёр талдаа мод эгнүүлэн тарьсан нэг л хязгааргүй нүүрэн тал үргэлжилсэн модон байшингуудыг хараад дахиад л дотор эвгүйцлээ. миний бодлоор дэгжирхэлийн дээд болсон кимонотой эмэгтэйчүүд хаашаа ч юм яаран хөлхөх бөгөөд сүүлд мэдэхнээ тэдний ихэнх нь эрчүүд байв даа.

тэгж тэгж байшингийн орох хаалганы дэргэд зогсоход ноён бэкку буугаад намайг дагахыг зангалаа. дараа нь тохиолдож болох хамгийн азгүй зүйл боллоо. сацу бас буух гэтэл ноён бэкку эргэж хараад буцаагаад түлхчихэв.

- суу. чи өөр газар очно гэв.

би ч сацу өөд, тэр ч над руу харлаа. бид 2 анх удаа бие биеэ мэдэрсэн байх. гэхдээ энэ нь хормын төдий үргэлжилж, би эргэн тойрноо олж харахгүйгээр орилон чарлалаа. ноён бэкку намайг үндсэндээ чирч байшинд оруулаад хөл дээр минь зогсоов. шатан дээр тансаг гэгчийн кимонотой, гайхалтай гоё хүүхэн зогсож байв. ноён танакагийн төрсөн хот Сензуруд гейшагийн кимоног хараад гайхширснаа би саналаа. гэхдээ энэ кимоно усны урсгал санагдуулам нимгэн мөнгөлөг хээтэй, намирсан, ялдамхан цагаан цэнхэр өнгөтэй, зүйрлэхийн аргагүй тансаг байлаа. усанд нь мөнгөлөг тулбага загас хөвж, түүнийг шүргэх ногоохон навчны дээрх усны мандлыг алтан утас нэвтлэн хатгасан торгон бүстэй, цэвэр торгоор оёсон кимоно байсанд би эргэлзсэнгүй. зөвхөн хувцас нь ч ер бүс байсангүй ээ. цайруулах энгэсэг зузаан түрхсэн царай нь нар туссан цагаан үүл мэт харагдана. ард нь бөөгнүүлэн боосон үс нь лак түрхсэн мэт гялалзах аж. үсэндээ өчүүхэн төдий хөдлөхөд гялтганах нарийхан мөнгөн утсан унжлагатай хуван сам хатгажээ.